



ХӨЛ ХОРИО БА ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ АСУУДАЛ

НЭГ. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсын Засгийн газар 178 дугаар тогтоол¹ баталж 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн. Тус шийдвэр гарснаар эрүүл мэндийн, албан, хувийн шалтгаанаар нийслэл, орон нутагт ирсэн иргэдийн зорчих эрхийг хязгаарлаад байна. Үүний улмаас гадаа, машиндаа хоноглох², хоол тэжээлийн хомсдолд орох, бага насны хүүхэд эцэг, эхээсээ тусдаа асрамж халамжийн гадна үлдэх³, ажил хөдөлмөр эрхэлж орлого олох боломжгүй болсон зэрэг олон сөрөг үр дагавар гарч байна. Нэгэнт хатуу хөл хорио тогтоож, гэртээ байхыг зөвлөж байгаа энэ цаг үед эдгээр иргэдэд төрийн зүгээс анхаарал хандуулж, яаралтай арга хэмжээ авах нь нэн чухал⁴. Энэхүү асуудлыг шийдэх сайн туршлага бол түр орон байр, хоол хүнсээр хангах явдал юм⁵. Мөн өөрсдийн амьдардаг орон нутаг руу боломжийн богино хугацаанд буцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Манай улсын хувьд 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл орон нутаг, нийслэлд гацсан иргэдийг хэрхэх талаар шийдвэр гаргасангүй. Гэтэл Улаанбаатар хотоос орон нутаг руу явах 86,000 гаруй иргэн, Улаанбаатар хот руу ирэх 5,300 гаруй иргэн бүртгүүлжээ.⁶ Үүн дээр бусад орон нутаг хооронд гацсан иргэдийн тоог нэмбэл нилээд өндөр үзүүлэлт харагдана. Улсын онцгой комиссоос 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр гаргасан шийдвэрээр тус иргэдийг 2020 оны 12 дугаар сарын 1-10-ны өдрүүдэд орон нутаг руу нь буцаах болов.⁷ Ингэхдээ “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”⁸-д заасны дагуу⁹ www.119.mn хаягаар нэвтэрч, зорчих шаардлага, иргэний болон эрүүл мэндийн мэдээллээ бөглөн хүсэлтээ явуулж, шинжилгээ өгөх газар, цагаа товлон. Иргэд зорчихоос 48 цагийн өмнө коронавируст халдварын шинжилгээ өгч, хариу сөрөг гарсан бол авто тээврийн үндэсний төвийн www.eticket.transdep.mn хаягаар нэвтэрч, тасалбар

¹ Монгол Улсын Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоол. 2020 оны 11-р сарын 11-ний өдөр, Дугаар 178

² <https://www.facebook.com/mongolty/videos/328994185135193> Орхон аймгаас Улаанбаатар хотод томографикийн шинжилгээ хийлгэх зорилгоор эхнэрийн хамт хөл хорио тогтоохоос өмнө буюу 2020 оны 11 сарын 10-ны өдөр хотод ирсэн. Гэтэл өнөөдрийн байдлаар хотоос гарах хөдөлгөөний хаасан тул Орхон аймагт буй гэртээ харих боломжгүй болж, өөрийн автомашиндаа хоног өнгөрүүлж байгаа тухай 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр мэдээлсэн байна.

³ <http://eagle.mn/r/79551> Өмнөговь аймгийн Ханбогд сумаас 11 сарын 10-нд нийслэлийг зорьсон нэг гэр бүлийн гурван хүн хотод хөл хорионд орж, гэрт нь 16 настай хүү, нэг ой дөрвөн сартай хүүхэд нь үлджээ. Гэвч нэг ой дөрвөн сартай бяцхан охин өвдөн эмнэлэгт байгаа учраас яаралтай буцах хүсэлтэй байгаагаа УОК болон холбогдох байгууллагуудад уламжилсан байна.

⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн дээд комиссарын газар. Ковид-19 удирдамж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 84 дэх тал

⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн дээд комиссарын газар. Ковид-19 удирдамж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 84 дэх тал

⁶ <https://nema.gov.mn/n/109524>

⁷ <http://eagle.mn/r/79515>

⁸ Монгол Улсын Шадар сайдын тушаал. 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр. Дугаар 146

⁹ Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 146 тушаалын хавсралт “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын 2.2, 2.3 дахь заалт.

захиалах юм. Иргэдэд албаны, хувийн болон нийтийн тээврээр зорчих боломжийг олгож байгаа бөгөөд буцаж очсоны дараа 14 хоног өөрийгөө тусгаарлах үүргийг хүлээлгэсэн.¹⁰ Энэ шийдвэр гарахаас 2 хоногийн өмнө Улсын онцгой комисс (УОК) ажлын хэсэг байгуулсан¹¹, түр журам гараагүй, апплекэйшн танилцуулагдаагүй зэргээс харахад энэ асуудлаар бэлтгэлгүй байсныг харуулж байна. Харин 86,000 иргэний PCR шинжилгээний зардлыг төр хариуцаж байгаа¹² нь тун зөв шийдэл юм.

Нийслэлээс гарах 86,000 хүний 70 хувь нийтийн унаагаар¹³ явахаар бүртгүүлсэн бөгөөд өдөрт 212 тээврийн хэрэгслээр нийт 8,500 хүнийг тээвэрлэхээр төлөвлөжээ.¹⁴ Тиймээс эдгээр иргэн хуваарьт өдрөө

хүлээх явцад орон байр, хоол хүнс, санхүүгийн хүндрэлтэй нүүр тулсаар байх тул хүнд нөхцөлд буй орон нутаг, нийслэлийн иргэдийг судалж, түр орон байр, хоол хүнсээр хангах ажлыг давхар зохион байгуулах нь зүйтэй. Иргэдийн зорчих эрхийг хангах нь зүйтэй ч нөгөө талдаа коронавируст халдварт цар тахлыг бусдад халдаахгүй байх нөхцөлийг давхар хангахаар энэ ажлыг зохион байгуулах шаардлагатай. Энэ хүрээнд зорчиж буй иргэдийг апплекэйшний тусламжтайгаар төлөвлөсөн газартаа хүрсэн эсэх, гэрийн хяналтад орсон эсэхийг хянах тухай ярьж байгаа ч ямар апплекэйшн хэрэглэх, хэрхэн татаж авах, хэдий хугацаанд хэрэгжүүлэх тухай мэдээлэл байхгүй байна.

ХОЁР. АСУУДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйлд “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй”,¹⁵ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭТОУП)-ын 12 дугаар зүйлд “Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байгаа аливаа хүн тухайн нутаг дэвсгэрийн дотор чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй”,¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.18 дахь хэсэгт “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй, Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно”¹⁷ хэмээн чөлөөтэй зорчих эрхийн тухай зохицуулсан.

Чөлөөтэй зорчих эрхийг дотоодод хязгаарласны хариу арга хэмжээний хүрээнд орон нутгийн иргэдийн хөдөлгөөнд QR код бүхий апплекэйшн ашиглахаар төлөвлөжээ.¹⁸ Энэ системийг хэрэгжүүлсэн сайн туршлага бүхий улс бол БНХАУ бөгөөд ухаалаг утсанд тус апплекэйшнийг суулгах хэлбэрээр тандалт, хяналтын систем ажилладаг.¹⁹ Тус апплекэйшний дагуу явсан газрын маршрут, уулзсан хүмүүс зэргийн мэдээллийг оруулахаас гадна өөрт илэрч буй биеийн шинж тэмдгийг тодорхойлсон хэсгийг бөглөх ёстой болно.²⁰ БНХАУ-ын хувьд эрх бүхий байгууллагаас ногоон, шар, улаан кодын алийг олгох эсэхийг шийдвэрлэдэг.²¹ Ногоон эрүүл мэндийн QR код нь зөвшөөрөгдсөн буюу чөлөөтэй зорчих боломжтой, шар эрүүл мэндийн QR код нь анхаарах буюу долоо хоногийн хугацаанд өөрийгөө тусгаарлах (self-quarantine), улаан эрүүл мэндийн QR код нь аюултай

¹⁰ Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Дугаар 146 тушаалын хавсралт “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын 4.5, 6.7 дахь заалт.

¹¹ <http://www.tv5.mn/> Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн мэдээллээс иш татав.

¹² <http://www.tv5.mn/> <https://www.montsame.mn/mn/read/244720> УОК-ын 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн мэдээллээс эш татав.

¹³ <https://nema.gov.mn/n/109524>

¹⁴ <https://nema.gov.mn/n/109524>

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/1271?lawid=1271>

¹⁶ <https://www.legalinfo.mn/law/details/1257>

¹⁷ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992/№1

¹⁸ <https://www.montsame.mn/mn/read/244602>

¹⁹ <https://edition.cnn.com/2020/04/15/asia/china-coronavirus-qr-code-intl-hnk/index.html>

²⁰ <https://edition.cnn.com/2020/04/15/asia/china-coronavirus-qr-code-intl-hnk/index.html>

²¹ <https://edition.cnn.com/2020/04/15/asia/china-coronavirus-qr-code-intl-hnk/index.html>

буюу 14 хоногийн хугацаанд өөрийгөө бусдаас тусгаарлахыг илтгэдэг байна.²²

Манай улсын хувьд энэхүү системийг ашиглан орон нутаг, нийслэлд ирж буй иргэдийг цар тахлын үеийн дэглэмийг хэрхэн сахиж байгаа эсэхэд хяналт, тандалт тавих боломжтой. Түүнчлэн QR код бүхий системийг ашиглан өөрийгөө тусгаарлах боломжийг олгосноор иргэд хөдөлмөрлөх, хувийн аж ахуй эрхлэх боломжтой болж, санхүүгийн хямралыг давахад тусалж, мөн хурдан хугацаанд мэдээлэл хүргэх боломжийг олгоно. Харин энэхүү системийг ашиглахдаа Эмнести интернэшнл болон 140 гаруй иргэний нийгмийн байгууллага хамтран гаргасан Ковид-19 цар тахалтай холбогдуулан дижитал хяналт шалгалт хийхдээ анхаарах нөхцөлийг зөвлөсөн мэдэгдлийг²³ анхаарч үзэх нь зүйтэй. Тус мэдэгдэлд Засгийн газрын авч буй арга хэмжээ ил тод, нээлттэй

байх, технологи ашиглан хяналт, ажиглалт хийхдээ хэдий хугацаанд үргэлжлэхийг тодорхойлсон байх, тус хугацаанд зорилгодоо хүрсэн бол цуцлах, хувь хүний нууцад халдахгүй байх, засгийн газар хувь хүний мэдээллийг цуглуулах, дамжуулах, боловсруулах, хадгалахтай холбогдсон аливаа төхөөрөмж, програм хангамж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахын тулд бүхий л шаардагдах арга хэмжээг авах зэргийг анхааруулсан байна.²⁴

Тиймээс технологи ашиглаж, цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах бол зорилгодоо нийцсэн бөгөөд тохирсон байх, хэн нэгэнтэй хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, халдашгүй эрхийг нь хүндэтгэх, хувь хүний нууцыг хадгалах, зөвхөн цар тахлын хүрээнд ашиглах, бусад нөхцөлд цуцлах, иргэдэд технологийн талаархи мэдээллийг ил тод, нээлттэй, хүртээмжтэй өгөхөд анхаарч ажиллах шаардлагатай.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Өөр орон нутагт зорчих эрх нь хязгаарлагдсан иргэд боломжит богино хугацаанд өөрийн орон нутагт буцах нөхцөлийг бүрдүүлэх;
2. Зайлшгүй шалтгаанаар зорчих эрх хязгаарлагдсан хүмүүсийг түр амьдрах байр, хоол хүнс, наад захын хэрэгцээг хангах нөөц төлөвлөгөөтэй байх;
3. Орон нутаг, нийслэлийн иргэдийг өөрийн зорчих газарт хүрэхэд нь ялгаварлан гадуурхахгүй байх;
4. Зорчих эрхэд хяналт тавих QR код бүхий апплекэйшн ашиглах заавар, зөвлөмжийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, урьдчилан мэдээлэл авах боломж олгох;
5. Цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахдаа иргэдийг хянан шалгах механизмыг бус иргэн өөрөө өөрийгөө хянах механизмыг ашиглах;
6. Эрүүл мэндийн QR код бүхий системд иргэдийн тусгаарлалтын дэглэмийн журам, мэдээ, мэдээлэл, анхаарах зүйл, өөрийгөө тусгаарлах хугацаа дуусч байгаа эсэхийг мэдэх хэсгийг оруулж өгөх;
7. Технологи ашиглаж, цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах нөхцөлд зорилгодоо нийцсэн бөгөөд тохирсон байх, хэн нэгэнтэй хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, халдашгүй эрхийг нь хүндэтгэх, хувь хүний нууцыг хадгалах, зөвхөн цар тахлын хүрээнд ашиглах, бусад нөхцөлд цуцлах.

²² <https://www.weforum.org/agenda/2020/03/coronavirus-covid-19-hangzhou-zhejiang-government-response/>

²³ <https://amnesty.mn/index.php/2019-06-05-14-51-12/545-2020-05-20?fbclid=IwAR1o33dKH7Ha7cOPb3TDZVCca6IaOuTp0wE8e1l1GwE02Q3Wm5uV3rQkgkY>

²⁴ <https://amnesty.mn/>

СУДАЛГААГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН:

А.Түвшинтөгс, Хуульч, Өмгөөлөгч

Д.Ганхүрэл, МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш

Э.Золзаяа, Хуульч, Өмгөөлөгч

Н.Лхамцэрэн, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш

ТАЙЛАНГ ЭМХЭТГЭЖ БИЧСЭН:

А.Түвшинтөгс, Хуульч, Өмгөөлөгч

САНАЛ ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.Хишигсайхан, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14240
Утас: (976) 76113207
Вэб сайт: www.forum.mn